

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2025 ОНЫ 07 ДУГААР САРЫН 08-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,
ХӨДӨӨ АЖ АХУЙН БОЛОН
ЭДИЙН ЗАСГИЙН
БАЙНГЫН ХОРООДЫН
ХАМТАРСАН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БОЛОН ЭДИЙН ЗАСГИЙН
БАЙНГЫН ХОРООДЫН ХАМТАРСАН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА**

2025 оны 07 дугаар сарын 08-ны өдөр, Мягмар гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 – 3
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	4 – 27

- 1. Байнгын хороодын хамтарсан тогтоолын төсөл /Ерөнхий хяналтын
сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай/**

4 – 27

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн болон Эдийн засгийн байнгын хороодын
07 дугаар сарын 08-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хамтарсан хуралдааны товч тэмдэглэл**

Эдийн засгийн байнгын хорооны дарга Р.Сэддорж ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хамтарсан хуралдаанд ирвэл зохих 44 гишүүнээс 26 гишүүн хүрэлцэн ирж, 59.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 33 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Л.Мөнхбаясгалан;

Чөлөөтэй: Ж.Алдаржавхлан, Э.Батшугар, Ж.Бат-Эрдэнэ, С.Бямбасүрэн, Ж.Ганбаатар, С.Ганбаатар, Б.Мөнхсөёл, П.Сайнзориг, Л.Соронзонболд, О.Цогтгэрэл, Д.Энхтүвшин;

Эмнэлгийн чөлөөтэй: С.Лүндэг, Х.Баттулга.

Нэг.Байнгын хороодын хамтарсан тогтоолын төсөл /Ерөнхий хяналтын сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Дэд дарга Ү.Амарбат, Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны референт Ц.Рэнцэнтогтох, Хяналт шалгалтын газрын ахлах зөвлөх Ч.Онончимэг нар байлцав.

Байнгын хорооны дарга Р.Сэддорж Ерөнхий хяналтын сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай Байнгын хороодын хамтарсан тогтоолын төслийг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Н.Наранбаатар, Ч.Лодойсамбуу, С.Цэнгүүн, Б.Жаргалан, Ц.Идэрбат, З.Мэндсайхан, Ж.Батжаргал, М.Бадамсүрэн, О.Батнайрамдал, С.Замира, Б.Уянга, Э.Болормаа, Б.Бат-Эрдэнэ нарын тавьсан асуултад Байнгын хорооны дарга Р.Сэддорж, Б.Бейсен нар хариулж, тайлбар хийв.

Хамтарсан хуралдааныг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Б.Бейсен 11 цаг 35 минутаас даргалав.

Б.Бейсен: Ерөнхий хяналтын сонсгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатарыг сонгоё гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 20

Татгалзсан: 13

Бүгд: 33

60.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Б.Бейсен: Ерөнхий хяналтын сонсголын хугацааг 2025 оны 09 дүгээр сарын 23-ны өдөр зохион байгуулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 12
Бүгд: 33
63.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Б.Бейсен: “Ерөнхий хяналтын, сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” Байнгын хороодын хамтарсан тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 12
Бүгд: 33
63.6 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 11 цаг 48 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хороодын хамтарсан хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хамтарсан хуралдаан 1 цаг 16 минут үргэлжилж, 44 гишүүнээс 30 гишүүн хүрэлцэн ирж, 68.2 хувийн ирцтэйгээр 11 цаг 49 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЭДИЙН ЗАСГИЙН
БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Р.СЭДДОРЖ

Тэмдэглэлтэй танилцсан:

БАЙГАЛЬ ОРЧИН,
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН
БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Б.БЕЙСЕН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ЗОХИОН
БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 07 дугаар сарын 08-ны өдөр, Мягмар гараг
Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхим
10 цаг 33 минут

ЭДИЙН ЗАСГИЙН БОЛОН БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООДЫН ХАМТАРСАН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Р.Сэддорж: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Хуралдаанд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя.

Хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн О.Амгаланбаатар, Т.Аубакир, М.Бадамсүрэн, Б.Бат-Эрдэнэ, О.Батнайрамдал, Н.Батсүмбэрэл, П.Батчимэг, Б.Бейсен, Х.Ганхуяг, М.Ганхүлэг, Б.Жаргалан, С.Замира, Ц.Идэрбат, Ч.Лодойсамбуу, Г.Лувсанжамц, М.Мандхай, Ц.Мөнхбат, Б.Найдалаа, Н.Наранбаатар, У.Отгонбаяр, Л.Соронзонболд, Р.Сэддорж, А.Ундраа, Б.Уянга, С.Цэнгүүн, Ж.Чинбүрэн, М.Энхцэцэг нарын Улсын Их Хурлын гишүүд хүрэлцэн ирсэн байна.

Хуралдааны ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж ирц 61.4 хувьтай бүрдсэн тул Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн болон Эдийн засгийн байнгын хороодын 2025 оны 07 сарын 08-ны өдрийн хамтарсан хуралдааныг нээснийг мэдэгдье.

Байнгын хороодын хамтарсан хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэг. “Ерөнхий хяналтын сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” Байнгын хороодын хамтарсан тогтоолын төсөл.

Хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу? Алга байна.

Хэлэлцэх асуудалдаа орёе. Тогтоолын төсөл тараагдсан байх. Тийм ээ.

Хэлэлцэх асуудал нэг. “Ерөнхий хяналтын сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” Байнгын хороодын хамтарсан тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Тогтоолын төслийг Та бүхэнд тараасан байгаа. Тогтоолын төслийг танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол.

Ерөнхий хяналтын сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.6 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 95 дугаар зүйлийн 95.5.5 дахь заалт, 120 дугаар зүйлийн 120.1.1 дэх заалт, 120.2 дахь хэсэг, 121 дүгээр зүйлийн 121.1, 121.13 дахь хэсэг, 122 дугаар зүйлийн 122.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэг, Нийтийн сонсголын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо болон Эдийн засгийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.Ерөнхий хяналтын сонсголыг ““Халзан бүргэдэйн” орд газрын ашиглалт, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл, эрсдэлийг нарийвчлан судлах” сэдвээр 2025 оны 09 дүгээр сарын 10-ны өдөр зохион байгуулахаар тогтоосугай.

2.“Халзан бүргэдэйн” орд газрын ашиглалт, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл, эрсдэлийг нарийвчлан судлах асуудлаарх ерөнхий хяналтын сонсгол даргалагчаар Монгол Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатарыг сонгосугай.

3.Ерөнхий хяналтын сонсголын зарыг нийтэд мэдээлж, бэлтгэл ажлыг ханган холбогдох хууль, журамд заасны дагуу зохион байгуулахыг Монгол Улсын Их Хурлын Тамгын газарт даалгасугай.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга, Эдийн засгийн байнгын хорооны дарга.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асууж, санал хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрсээ өгье.

Б.Жаргалан гишүүнээр тасалъя.

Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууна.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Би энэ ерөнхий хяналтын сонсголд яагаад зохион байгуулах ёстой болсон бэ гэдгийг асуумаар байна.

Энэ дээр бичихдээ ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүд “Халзан бүргэдэйн” ордыг ашиглахад тухайн бүс нутгийн байгаль

орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл, эрсдэл, түүнийг бууруулах талаар ямар арга хэмжээ авч хэрэгжүүлэх нь тодорхойгүй хэвээр байна гэж бичсэн байна.

Би үүнийг сайн ойлгохгүй байна.

Энэ Байгаль орчны яам чинь ажил хаясан юм уу? Байгаль орчны яамны хийх ёстой ажил шүү дээ. Тэгээд Байгаль орчны яамныхан ажил хийхгүй болоод энэ дээр ийм үндэслэл орж ирээд ерөнхий хяналтын сонсгол зохион байгуулагдах гэж байгаа юм уу? Энэ чинь хуультай шүү дээ.

Тэгээд хуулиа хэрэгжүүлээд Байгаль орчны яам нь тэр ерөнхий үнэлгээ, нарийвчилсан үнэлгээгээ хийгээд байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл, эрсдэлээ тооцоолоод, аж ахуйн нэгж нь өөрөө үүнийгээ тооцож гаргаад Байгаль орчны яаманд өгөөд явж байх ёстой.

Тэгээд би үүнийг сайн ойлгохгүй байна. Яг үнэндээ.

Ямар үндэслэлээр нэг компанитай холбоотой асуудал орж ирж байгаа вэ гэдгийг.

Ер нь төрийн оролцоо ихсэх хэрээр хувийн хэвшлийн эдийн засагт үзүүлэх нөлөөлөл чинь багасаж байгаа шүү дээ.

Бид хуультай холбоотой асуудлууд, энэ хууль хэрэгжүүлж байгаа төрийн яамд, агентлагтай холбоотой асуудлуудыг ер нь Улсын Их Хурал дээр татаж оролцуулж ирдэг болж байгаа юм уу? Эсвэл энэ жишгээр цаашдаа явах юм уу?

Би төрийг ойлгохгүй байна.

Сая эрчим хүчний хуулийг дахиад яаралтай горимоор хэлэлцүүлэхээр Улсын Их Хурлын чуулганд оруулж ирж байгаа. Хоёр дахь удаагаа. Үүнийг бас ойлгохгүй байна.

Тэгээд төрийн оролцоог илүү их л болгоод байгаа юм шиг л санагдах юм. Хувийн хэвшил чинь яаж ажиллах юм. Нэг талдаа хувийн хэвшлээ дэмжинэ, төрийн оролцоог багасгана гээд зарлаад байдаг. Яг бодит үйлдэл дээрээ төрийн оролцоо чинь ихсээд хувийн хэвшил чинь хумигдаад байна шүү дээ. Тэгээд яаж энэ эдийн засаг чинь босох юм. Энэ дээрээ би хариулт авмаар байна. Тэгээд тодруулах юмаа тодруулъя. Баярлалаа.

Р.Сэддорж: Б.Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 121 дүгээр 121.1-д энэ хуулийн 119.1-д заасан хүсэлтийг хүлээн авснаас хойш, эсхүл энэ хуулийн 119.3, 119.4-д заасны дагуу хүсэлтийг дэмжсэнээс хойш

ажлын 5 өдрийн дотор холбогдох Байнгын хороо, Байнгын дэд хороо сонсголыг товлон зарлана гэсэн ийм хуулийн заалттай.

Яг сэдвийн талаар сонсгол дээрээ л ярих юм байна. Хуулиар. Одоо тов л зарлана. Тэгээд 09 сарын 10-ыг хүртэл гишүүд шаардлагатай мэдээллийг авч танилцах бүрэн боломжтой юм байна.

Н.Наранбаатар гишүүн.

Н.Наранбаатар: Байнгын хорооны гишүүдэд энэ өглөөний мэнд хүргэе.

Ерөнхий сонсголын сэдвийг “Халзан бүргэдэйн” орд газрын ашиглалт, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл, эрсдэлийг нарийвчлан судлах гэж.

Сэдэв нь яагаад ийм байгаа юм. Энэ дээр яагаад тэр нийгэмд нөлөөлөх нөлөөллийг оруулаагүй юм бэ? Зөвхөн байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг л судлах гэсэн байгаа. Энд чинь хүн байгаа шүү дээ. Хүн амьдарч байгаа бүс нутаг. Малчид байгаа. Ойр хавьд нь сум, орон нутаг, суурин газар байгаа.

Тэд нарт ямар хэмжээгээр нөлөөлөх юм. Хүний эрүүл мэндэд яаж нөлөөлөх юм. Монгол Улсын Үндсэн хуульд хүн эрүүл, аюулгүй орчинд ажиллаж амьдрах эрхтэй гээд заасан байгаа.

Тэгээд энэ эрх нь зөрчигдөж байгаа маш олон тохиолдлууд, газрууд байгаа. Ялангуяа уул уурхайтай бүс нутаг, уул уурхайтай сум орон нутаг, багийн нутаг дэвсгэр дээр хүмүүсийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх нь зөрчигдсөн ийм асуудал маш их байгаа. Энэ уул уурхайгаас болоод хүмүүсийн эрүүл мэнд, өвчлөл, харшил гээд маш олон асуудлууд. Цаашлах юм бол малд нөлөөлдөг. Бэлчээрийн ургамлын нөлөөлөл, тоосжилт гээд олон асуудлууд байдаг. Үүгээрээ дамжаад нийгэмд сөргөөр нөлөөлдөг ийм асуудлууд байдаг.

Мөн байгаль орчин, нийгмийн нөлөөллөөс гадна эдийн засгийн нөлөөлөл гэж байх ёстой. Тэнд ажиллаж амьдарч байгаа, олон жил нутаглаж байгаа хүмүүсийн нөлөөлөх нөлөөлөл, тэр хүмүүсийг нүүлгэн шилжүүлэх, зардал чирэгдэл гээд энэ асуудлуудыг нэгмөсөн хамтад нь судлахгүй юм уу?

Яагаад зөвхөн ордын ашиглалт, тэгээд байгаль орчны сөрөг нөлөөлөл гээд хоёрхон зүйлийг л оруулж өгсөн байгаа юм. Яагаад ийм хоёрхон зүйлийг л судалж үзэх юм бэ?

- Нийгмийн асуудал,
- хүний асуудал,
- малын асуудал,
- эрүүл мэндийн асуудал,

- сум орон нутгийн эдийн засгийн асуудал,
- сум орон нутгийн өгөөжийн асуудал гээд олон асуудал байдаг шүү дээ.

Аливаа нэгэн төсөл.

Ер нь энэ төслүүдийг яагаад иргэд эсэргүүцээд байгаа юм гэхээр зэрэг энэ олон жил үе дамжсан нутгаас нь хөөх, мөн бэлчээр нутаггүй болох, эрүүл мэндэд нь сөргөөр нөлөөлөх. Цаашлах юм бол баг, сумд нь ямар ч үр өгөөж байхгүй. Бүх орлого, төсөв, татвар, АМНАТ бүх юмнуудыг нь улсын төсөвт татаж авдаг. Ийм нөхцөлд л энэ хүмүүс чинь бухимдаад ингээд бослого тэмцэл гаргаад байгаа шүү дээ.

Тийм учраас иж бүрэн, бүгдийг нь орхигдуулалгүй энэ хяналтын сонсгол дээр ярих нь зүйтэй байх гэж бодож байгаа. Тэгээд хариулт авъя. Тэгээд дараа нь саналаа хэлье.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал тэргүүтэй хэдэн гишүүн билээ. 15 гишүүнээс ийм хүсэлт ирүүлсэн.

Хүсэлтэд ирүүлсэн сэдвийн дагуу л зарлаж байгаа.

Энэ удаагийн хамтарсан хуралдаан зөвхөн тов л зарлана. Хуралдаан даргалагчийг тогтооно. Сонсгол дээрээ энэ бүгдийг яриад явах хэрэгтэй.

Тэгээд гишүүд 09 сарын 10 хүртэл бүрэн мэдээлэл авах боломжтой юм байна.

Н.Наранбаатар гишүүн тодруулъя.

Н.Наранбаатар: Тэгэхээр би ойлгохдоо Байнгын хорооны тогтоол гаргаж батлах гэж байгаа юм байна гэж ойлгосон.

Тэгээд бид нар тарааж өгсөн тогтоол дээр чинь сонсгол хийх сэдвийг нь “Халзан бүргэдэйн” орд газрын ашиглалт, байгаль орчинд үзвэл сөрөг нөлөөлөл, эрсдэлийг нарийвчлан судлах л гэж байгаа байхгүй юу.

Тэгэхээр миний хувьд үүнийг батлах бололцоо алга. Яагаад гэвэл сэдэв нь хэтэрхий өрөөсгөл байна. Тэгээд миний санал юу байна вэ гэхээр энэ орд газрын ашиглалт, байгаль орчин, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөлөл, эрсдэлийг нарийвчлан судлах гэдэг сэдвийг нь баталж байж цаашаагаа явах нь зүйтэй байх гэж бодож байна.

Тийм учраас дэмжих боломжгүй байна.

Р.Сэддорж: Б.Бейсен даргын микрофоныг.

Б.Бейсен: Энэ зөвхөн Халзан бүргэдэйн асуудал биш. Би Их Хурлын даргатай бас уулзсан.

Уг нь Халзан бүргэдэйн асуудлыг манай Байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн байсан.

Тэгэхдээ Хянан шалгах түр хороо байгуулах тухай хүсэлт гаргасан О.Батнайрамдал гишүүний юугаар нэлээн олон гишүүд. Энэ удаад зөвхөн Халзан бүргэдэйн асуудал. Дараа нь бусад Өмнөговийн чинь уурхайн асуудал ч юм уу, нэг доор бүгдийг нь сонсгол хийх боломжгүй гээд дарга асуусан. Би сая бас орж асууж гарлаа.

Тэгэхээр энэ удаагийн зөвхөн Халзан бүргэдэйн чиглэлийн тогтоол гэсэн. Тэгээд энэ Хянан шалгах түр хороо бол дараа нь тэр бусад уурхайн чиглэлээр бас сонсгол хийж болно гэсэн.

Р.Сэддорж: Энэ удаа сэдэв бол ерөөсөө ирсэн бичиг. Д.Амарбаясгалан Их Хурлын даргын хувьд Их Хурлын гишүүнийхээ хувиар бланк дээрээ 15 гишүүн гарын үсэг зураад Халзан бүргэдэйн орд газрын ашиглалтын асуудлаар ерөнхий хяналтын сонсгол явуулах хүсэлт гаргасан.

Тэгээд энэ сэдвийн дагуу л. Өнөөдөр сэдэв ярихгүй юм байна. Хуулиараа. Ингээд дараагийн гишүүддээ асуулт асуулгая.

Ч.Лодойсамбуу гишүүн.

Ч.Лодойсамбуу: Энэ хяналтын ерөнхий сонсгол гэж байгаа юм.

Хяналтын сонсгол гэдэг нь одоо уг нь тэр ажил нь яваад, эхлээд, тэгээд тэнд нь юу болоод байгааг уг нь хянаж, асуудал хөндөж тавьж байх ёстой юм шиг. Логик нь.

Одоо бараг энэ сонсгол чинь явуулах юм уу, үгүй юм уу гэдгээ шийдэх гээд байгаа юм уу хаашаа юм.

Яах вэ, энэ ингэсэн юм л даа. Их Хурлын дарга тэргүүтэй баруун бүсийн гишүүд очиж замын нээлт хийгээд, тэнд нь энэ Халзан бүргэдэйн ордтой холбоотой санал хэлж байгаа нь нутгийн болон нутгийн биш хүмүүсийн цугларалт асуудал тавиад, тэгээд ер нь олон нийтийнхээ өмнө хэлэлцье гэсэн юм.

Үүний гол асуудал нь юу вэ гэхээр мэдээлэл алга байна. Төр нь өөрөө яах гэж байгаагаа тодорхой шийдэхгүй байна. Шийдсэн бол шийдвэрээ хамгаалахгүй байна.

Тэгээд энэ үйл ажиллагаа явснаараа үнэхээр байгаль орчин, нийгэм, эдийн засагт ямар сайн болон сөрөг үр дагавартай юм бэ гэдэг талаар мэдээлэл өгөхгүй байна. Мэдээлэл хийх үүрэгтэй. Тийм ажил хийдэг хүмүүс нь хангалттай мэдээлэл өгөхгүй байна.

Тэгээд хоёр талдаа мэдээлэл дутсанаас үүдээд одоо ингээд сонсьё гээд сууж байгаа юм.

Хоёр асуулт байна. Байнгын хороон дарга аа.

Энэ сонсголыг даргалагчийг түрүүн Б.Баярбаатар гишүүн гээд танилцуулах шиг болох юм. Энэ хэний өгсөн нэр юм? Хаанаас яаж сонгосон юм?

Хоёрдугаарт, одоо энэ хоёр Байнгын хороо нэгдэж хуралдаж байгаа. Даргалагчийг эндээсээ сонгох уу? Тийм боломж байна уу? Сонгоё гэдэг санал байна. Асуулт байна.

Гуравдугаарт, энэ зөвхөн байгаль орчинтой холбоотой бид яриад өнгөрөх юм бол одоо хүртэл бид нарын тайлж чадахгүй яваад байгаа тэр уул уурхайн популизмыг улам томруулах л эрсдэлтэй болно.

Тэгэхээр энэ бол эдийн засгийн агуулгатай, эдийн засгийн өндөр ач холбогдолтой. Цаашдаа бид энэ уул уурхайн популизмаас салах ёстой.

Тийм учраас Эдийн засгийн байнгын хорооноосоо, дээр нь сөрөг хүчнээсээ, цөөнхөөсөө энэ хуралдаан даргалагчаа сонгоё.

Тийм учраас сонгох гарц гаргалгаа гаргаж ирж, Байнгын хороо одоо хуралдаж нэр дэвшигчдээ тодруулж, сонгон шалгаруулъя гэдэг ийм санал байна. Гурван асуулт байна.

Р.Сэддорж: Ц.Идэрбат гишүүнийг нэмээрэй. Б.Бейсен дарга эхний асуултад хариулна.

Б.Бейсен: Яг энэ асуудлыг би түрүүн Их Хурлын дарга, дэд дарга нараас бас асуусан.

Тэгэхдээ хяналтын сонсголыг хянан шалгах түр хороо энэ хүсэлт гаргаад байгуулсан байгаа. О.Батнайрамдал гишүүн.

Тэд нарын дотроос, түр хорооны дотроос сонгосон байхгүй юу.

Тэгэхээр иргэдийн санал хүсэлтийг авна. Энэ чинь хуулийн 121.11, 121.2-т иргэдийн санал, хүсэлтийг аваад 14-өөс доошгүй. Хамгийн доод талын хугацаа. Сар хүртэл санал, хүсэлтийг нь авч байгаад дараа нь 30 хоногийн дотор. Тэгэхээр чинь бараг 2 сар болох гэж байна л даа. Тэгээд хяналтын сонсгол хийх юм.

Урьд нь ковид дээр бид бас хяналтын сонсгол хийж байсан. Тэгээд үүний дагуу хий гэсэн.

Б.Баярбаатар гэдгийг Их Хурлын дарга өгсөн. Орон нутгийн улсуудаас өгвөл тэгээд бас улс төржсөн, тэгээд энэ ажил явахгүй тийм асуудал болох байх. Орон нутгаас ерөөсөө томилж болохгүй гэдэг асуудал гарсан.

Р.Сэддорж: Тэр хувийн хэвшлийг дэмжих. Энэ бол нөгөө “Mongolian National Rare Earth Corp” компаниас сонсгол хийж өгөөч ээ. Нээлттэй яриа хийе гэсэн ийм хүсэлт ирсэн юм байна шүү. Түрүүнд асуусан гишүүдэд хариулт өгье.

Тэгээд Улсын Их Хурлын гишүүн санал гаргаад санал хурааж болно шүү дээ. Сонсгол даргалагч дээр. Нээлттэй.

С.Цэнгүүн гишүүн.

С.Цэнгүүн: Оглөөний мэнд хүргэе.

Тэгэхээр чухал ашигт малтмалтай холбоотой асуудал дээр, ер нь бид уул уурхайн популизмаа зогсоомоор санагдаж байгаа.

Тэгээд аж ахуй нэгж нь ч өөрсдөө орон нутагтайгаа учраа олж чаддаггүй. Тэгээд энэ асуудлаасаа болоод хэдэн жилээр ч хамаагүй хөрөнгө оруулагч нар нь хохироод яваад байдаг.

Гэтэл манай Монгол Улс уул уурхайн орон юм. Тэгээд Өмнөговийос л ихэнх бүх дотоодын нийт бүтээгдэхүүнийнхээ дийлэнхээ цуглуулдаг байж бусад аймгууд нь энэ бусад өөр төслүүдээ эсэргүүцээд байгаа нь өөрөө учир дутагдалтай байгаа юм.

Тэгэхээр улсын төсвийн хөрөнгө оруулалтыг бусад аймгууд ч гэсэн хүртэж байгаа бол бид бусад аймгууд дээрээ ч гэсэн чухал төслүүдээ хөдөлгөөд явахын талд байх ёстой гэж миний зүгээс харж байгаа юм.

Дээрээс нь Болдын Уянга гишүүнтэй хамтраад энэ чухал Ашигт малтмалын тухай хууль дээр ажиллаж байгаа. Энэ дээр бид ойлголтуудаа цэгцэлж авах ёстой.

Ер нь

- нийгэм, эдийн засгийн хувьд ямар байгаа юм,
- байгаль орчин дээр ямар юм,
- бид бүхэн яаж хариуцлагатай уул уурхайг дэмжих ёстой юм

гэдэг тал дээр шинжлэх ухаанчаар хандаж, шинжлэх ухаанчаар шийдвэр гаргадаг баймаар байна.

Түүнээс биш хэдэн хүн эсэргүүцэж байна гэдэг нэртэй. Тэр нь яг орон нутгийн иргэд юм уу, үгүй юм уу гэдэг нь мэдэгдэхгүй ийм байдлаар аж ахуйн нэгжүүдийг ч хохироогоод, хөрөнгө оруулагч нарыг ч хохироож, ийм байдалтай явах юм бол манай Монгол Улс өөрөө хөгжих боломжгүй.

Тэгээд **RARE EARTH ELEMENTS** гээд. Энэ бол өөрөө бид нарыг дэлхийтэй холбох маш том гарц байгаа юм. LED дэлгэц, тэгээд зөөврийн компьютер гээд бид бүхний өдөр тутамдаа ашигладаг бүх өндөр технологийн зүйлсэд ордог зүйл байгаа юм.

Тэгээд энэ утгаараа бид бүхэн энэ асуудлыг уран шиг байдлаар иргэддээ анхнаас нь буруу ойлгуулж болохгүй. Тэр утгаараа бас энэ хяналтын сонсгол дээр сонсголын тов зарлаад даргалагчийг сонгох юм байна.

Тэгээд миний зүгээс, залуу хүний хувьд энэ хяналтын сонсголыг даргалаад явах хүсэлтээ бас гаргая.

Р.Сэддорж: 3.Мэндсайхан гишүүнийг нэмээрэй. Б.Жаргалан гишүүн.

Б.Жаргалан: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Гишүүдийн хэлж байгаа саналуудтай санал нэг байна. Энэ ерөнхий хяналтын сонсголын сэдэв нэлээн явцуу байна.

Тэгэхээр нэгэнт тогтоолын төсөл одоо бид нар батлах гээд хэлэлцэж байгаа учраас энэ сэдвийнхээ агуулгыг жаахан эргэж харвал зохих юм болов уу гэж бодогдож байна.

Тэгээд энэ сонсгол даргалагчийн тухайд гэх юм бол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 122-т заасны дагуу одоо энэ Байнгын хорооны бүрэлдэхүүн даргалагчаа сонгоод явах ийм зохицуулалттай юм байна.

Тэгэхээр энд хүмүүс нэрээ дэвшүүлж байна гэж ойлголоо.

Тэгэхээр тэр дагуу нэр дэвшигчид дундаас Байнгын хорооны гишүүдийн санал хураалтаар олонхын саналаар даргалагч сонгогдох юм байна.

Тэгээд хугацаа нь 09 сарын 15 гэж хэлэх шиг боллоо. Тийм ээ?

Тэгэхээр манай гишүүд хугацаан дээр бас саналуудаа хэлмээр байна. Яагаад вэ гэхээр бид анх удаа шууд тогтоол ороод ирж байгаа. Тэгээд энэ болгон дээр одоо жишээлэх юм бол чуулган эхлэхээс өмнө хэзээ, ямар хугацаанд хийх юм бол? Хамгийн үр өгөөжтэй. Бас олон нийтэд мэдээлэл өгсөн аль аль талынх нь байр сууриудыг сонссон ийм зүйл болж чадах вэ гэдэг дээр Байнгын хорооны гишүүд маань нэг бодитой шийдвэр гаргамаар байна.

Тэгээд сая Р.Сэддорж дарга тухайн байгууллагаас нь, компаниас нь бас нэг захидал ирсэн гэж хэлсэн үү?

Тэгэхээр тэр бүх мэдээллүүдээ уг нь Байнгын хорооны гишүүддээ өгмөөр байгаа байхгүй юу. Яагаад гэхээр бид сая л нэг тогтоолын төсөл хараад л. Өөр харах юмгүй сууж байна л даа.

Тэгэхээр тэр одоо яг ямар ямар материалууд ирсэн. Тэгээд энэ сонсголтой холбоотой хаана хаанаас саналууд ирсэн. Гишүүдийн санал орж ирсэн юм байна.

Түүнээс гадна өөр өөр ямар материалууд байгаа юм. Уншиж судлах зүйл юу байгаа юм. Тэр бүх зүйлүүдээ гишүүддээ нээлттэй тараах нь зөв байна.

Яагаад вэ гэхээр яг ийм асуудал дээр бид нэгдсэн ойлголттой. Байнгын хорооны гишүүд ч тэр, одоо энэ сонсголыг зохион байгуулах улсууд ч тэр бүгдээрээ бас нэг тийм нэгдсэн ойлголттой ийм зөв цэгээс эхлэх нь зүйтэй. Эс бөгөөс энэ бол Монголын эдийн засагт маш үр нөлөөтэй. Цааш цаашдын хөрөнгө оруулагчдын талаас ч тэр их анхааралтай ажиглаж байгаа сэдэв учраас бас тийм хөнгөн хуумгай шийдвэр гаргах нь зохимжгүй санагдаж байна.

Р.Сэддорж: З.Мэндсайхан гишүүнийг нэмээрэй гэсэн. Ж.Батжаргал гишүүн нэмэх юм уу. Ж.Батжаргал гишүүнийг нэмээрэй. М.Бадамсүрэн гишүүнийг нэмээрэй.

27 гишүүнд хүсэлт ирсэн юм байна. Б.Жаргалан гишүүн. Энэ компаниас, нутгийн иргэдээс. Тэгээд 27 гишүүн зурсан юм байна шүү. 15 гишүүн биш 27 гишүүн зураад ингээд явж байгаа юм байна.

Гишүүд зөвхөн Байнгын хороонд энэ хүсэлтийг л өгсөн. Өөр ямар нэгэн мэдээлэл өгөөгүй. О.Батнайрамдал гишүүнийг нэмээрэй.

Асуулт, үг цуг явж байгаа. С.Замира гишүүнийг нэмье.

Ингээд Ц.Идэрбат гишүүн. Б.Уянга гишүүнийг нэмье.

Ц.Идэрбат: Өдрийн мэнд хүргэе.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад зүгээр саналаа хэлэхэд тухайн ордын асуудал маш олон удаа яригдаж байгаа, маш олон удаа тухайн аж ахуйн нэгж нь үйл ажиллагаа явуулах гэж очиж байгаа, маш олон удаа эсэргүүцэлтэй тулж байгаа гээд л зөндөө л юм болж байгаа.

Тэгээд энэ нь огт мэдээлэлгүйтэй холбоотой л юм билээ шүү дээ. Тийм.

Тэгэхээр ер нь яах вэ уул уурхай ярихаар улс төржлөө гэдэг. Уул уурхай ярихаар уул уурхайн попролт гэдэг бас нэг шинэ нэр томьёо гарч ирж байх шиг байна.

Манай уурхайн салбар хэдийгээр улс орны эдийн засагт маш ашигтай, үр өгөөжтэй явж ирж байгаа боловчиг цаана нь гарч байгаа хор хөнөөл нь бас их байгаад байгаа учраас ард иргэд үүнийг чинь бас дэмжиж өгөхгүй байгаад байгаа юм.

Томоохон төсөл, хөтөлбөр хэрэгжихээрээ дандаа алдагдалтай юмнууд яваад байгаа учраас ард иргэд чинь үүнийг чинь эсэргүүцээд байгаа байхгүй юу.

Ер нь ийм кейсүүд нь гараад ирэхээр энэ ч гэсэн тийм байх гэсэн тийм хардлага бас ний нуугүй хэлэхэд хаана ч байгаа юм билээ.

Тэгэхээр ард иргэд нь ч тэр, төр засаг нь ч тэр, тэр ашиглах аж ахуйн нэгж нь ч тэр яг юу, яаж ашиглах юм, ямар үр дүнтэй юм, эдийн засгийн хувьд, бүс нутагт, улс оронд ямар үр өгөөжтэй юм, байгаль орчинд ямар хор хөнөөлтэй юм гээд олон талаас нь яриад, хэлээд энэ төсөл би явах болов уу гэж бодож байгаа.

Түүнээс биш өнөөдрийн байдлаар ингээд харанхуйгаар очоод л ухна гэвэл ухуулахгүй гэдэг нөгөө тэмцэл чинь дахиад л тэнд өрнөөд л, тэр аж ахуйн нэгжийн чинь ажил нь явж өгдөггүй, ингээд нэг ийм утгагүй байдалд орох байхгүй юу.

Тэгэхээр эхнээсээ бүх юм нь тодорхой болоод, хаана хаанаа ойлголцолд хүрээд явчихвал хэн хэндээ амар. Жишээ нь, энэ “Алт” төсөл. Хэдэн жилийн өмнө Ерөнхийлөгч У.Хүрэлсүх дарга Ерөнхий сайд байхдаа, Л.Оюун-Эрдэнэ Ерөнхий сайд Хэрэг эрхлэхийн дарга байхдаа Гутайн алтны ордыг байгаль орчинд асар их хор хөнөөлтэй юм байна гээд л цуцалсан шүү дээ. Тэгээд өнөөдөр одоо ухна гэж байгаа.

Үүнийг чинь ард иргэд бас дэмжихгүй байгаа шүү дээ. Энэ бол бас л энэ Халзан бүргэдэйн ардын араас орно. Зүгээр тэнд очоод ухуулаад сууж байдаг хүмүүс гэж бол байхгүй.

Тэгэхээр ухлаа гэж бодоход эдийн засагт ямар нөлөөтэй юм? Бүс нутаг, аймаг, орон нутагт нь, улс орны эдийн засагт ямар нөлөөтэй юм гэж. Би тэгээд энэ олон хүмүүсийн ярианаас харахад Монгол ер нь сүүлийнхээ алтны үүц рүү орох гэж байгаа юм шиг л юм яриад байгаа юм. Бид тийм хүнд байдалд яг орсон уу, ороогүй юу ч гэдгээ бас эргэж яримаар юм шиг.

Тэгэхээр энэ дээр Байгаль орчны байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо ч гэсэн бас... /минут дуусав/

Р.Сэддорж: Баярлалаа. Тэгээд одоо энэ гишүүдийн ярьж байгаа саналууд маш зөв зүйтэй саналууд байна. Тэгээд зайлшгүй энэ сонсгол дээр ярих юмнууд л энэ байна.

Тэгэхээр өнөөдрийн хувьд зөвхөн сар, өдрөө, тэгээд хуралдаан даргалагчаа томилоод л.

Тэгээд 09 сарын 10 хүртэл бүх гишүүд маань ярих хөөрөх судлах юмнуудаа холбогдох төрийн байгууллагуудаас татаж аваад тэгээд 10-д яг сонсгол дээрээ сайн ярих шийдвэрээ танилцуулах юм байна.

Э.Болормаа гишүүнийг нэмье. З.Мэндсайхан гишүүн.

З.Мэндсайхан: Би энэ ерөнхий хяналтын сонсгол явуулахыг дэмжиж гарын үсэг зурсан гишүүн байна.

Яагаад гэхээр Ховд аймгийн Мянгад сумд үүсээд байгаа Халзан бүргэдэйн ордын ашиглалтын асуудал яалт ч байхгүй Ховд аймгийн иргэдийн хувьд мэдээлэл байхгүй, аж ахуйн нэгжийн хувьд ямар нэгэн төслийн талаарх хариуцлагатай уул уурхайн талаарх үүргээ биелүүлэхгүй байгаагаас үүдээд иргэдэд мэдээлэлгүйгээсээ болсон ийм асуудал үзэж байгаа юм.

Тэгээд гишүүдэд хэлэхэд Их Хурлын дарга зам нээх гээд очингуут Ховдын ард түмэн эсэргүүцсэн асуудал огт биш. Энэ бүтэн хоёр, гурван жил үргэлжилж байгаа асуудал.

Өмнө нь Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ очихдоо нутгийн иргэд өөрөө дэмжихгүй бол энэ төслийг явуулахгүй гэж өөрийн биеэр Монгол Улсын Ерөнхий сайд мэдэгдсэн.

Тэнд нэг их гаднынхан очоод үймүүлээд байгаа юм байхгүй. Энэ дээр манай Э.Болормаа гишүүн бас мэдэж байгаа байх. Бид хоёр хоёулаа Ховдын ард түмний төлөөлөл болсон гишүүд.

Тэнд нутгийн иргэд маань энэ тайван амьдрах эрх нь зөрчигдөх вий дээ. Уур уурхайгаас үүссэн байгаль экологийн сүйрэл болох вий дээ. Энэ хүнд элемент болон байгалийн ховор элементийн талаарх мэдээллээ өгөөч ээ гэдэг ийм л эсэргүүцэл явж байгаа. Тэнд ямар нэгэн популизм байхгүй. Тэрийг мушгиж болохгүй ээ гэдгийг гишүүдэд хэлье.

Нэгэнт хурал даргалагчийн асуудал дээр ярьж байгаа бол би Б.Баярбаатар гишүүнийг би албан ёсоор нэр дэвшүүлье гэж бодож байна. Энэ дээр санал хурааж өгөөч гэж хэлмээр байна.

Хоёрдугаарт, энэ ерөнхий сонсголын товыг маш яаралтай хуралдуулж өгөх хэрэгтэй байна. 9 сар гэж хойш нь татмааргүй байна. Наадмын дараа хуралдуулаад өгөөч ээ.

Иргэдийн тэнд үүсээд байгаа бухимдлыг төр сонсох ёстой. Хариуцлагатай уурхайг бид цааш нь хөгжүүлье гэж ярьж байгаа бол нэгэнт олгосон лицензээ төр нь өөрөө аж ахуйн нэгжийн өмнө хамгаалдаг байх ёстой. Тэр нутгийн иргэдэд ямар үйл ажиллагаа явуулах гэж байгаа талын мэдээллээ өгдөг байх ёстой.

Төр үүргээ биелүүлэхгүй байгаагаас болоод иргэд, аж ахуйн нэгжийн хооронд зөрчил үүсээд байна. Энэ асуудлыг нэг талд нь гаргах ёстой. Нэг талд нь гаргахын тулд энэ ерөнхий сонсголыг маш хурдан явуулах нь зүйтэй.

Би хугацааны хувьд 7 сард багтааж хийж өгөөч ээ гэж Байнгын хорооны даргаас хүсэлт тавьж байна. Б.Баярбаатар даргыг би албан ёсоор дэвшүүлж байна.

Р.Сэддорж: Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 121.11-д энэ хуулийн 121.2-т заасны дагуу сонсголын товыг нийтэд мэдээлснээс хойш 14-өөс доошгүй хоногийн хугацаанд сонирхогч этгээдээс тухайн сонсголын асуудлын талаарх саналыг цахимаар, эсвэл шуудангаар хүлээн авах бөгөөд нэр, хаяггүй саналыг бүртгэхгүй гэсэн байна.

Ийм учраас 8 сарын дунд хүртэл гараад явчих юм байна. Энэ хугацаа бол. Тэгээд л 09 сарын 10 гэж тогтоосон байна. Тийм санал оруулсан байна.

Гишүүдийн үгийг протоколд тэмдэглэж байгаа.

Ж.Батжаргал гишүүн.

Ж.Батжаргал: Гишүүдийнхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Ерөнхий хяналтын сонсгол явуулах тухай асуудал яригдаж байгаа юм байна. Дэмжье.

Гэхдээ ерөнхий хяналтын сонсгол явуулах зохицуулалт нь бидэнд байж байгаа юм. Эрх зүйн хувьдаа. Харин сэдэв, нэршил нь яг одоо хийхээр болж байна уу, үгүй юу гэдэг юмаа нэг анзаарах ёстой. Бид.

Гуравдугаарт, ерөнхий хяналтын сонсголыг заавал Төрийн ордонд хийх хэрэг байна уу? Тэр нутаг оронд нь хийвэл яадаг юм? Ховдод нь гэдэг юм уу, эсвэл тэр Халзан бүргэдэйг хамаарч байгаа сумд нь гэдэг юм уу, тэнд нь хийж, тэр иргэдэд, орон нутагт нь бодитой мэдэх тэр эрх боломжийг нь бүрэн олгох хэрэгтэй. Би ийм байдлаар энэ асуудлыг зохицуулах нь зүйтэй болов уу гэж ойлгож байна.

Нэгэнтээ ашиглалтын үйл ажиллагаа явж байгаа юм бол байгаль орчны нарийвчилсан үнэлгээ хийгдсэн байх ёстой. Байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөө тухайн орон нутгийн багийн иргэдийн Нийтийн Хурлаар батлагдсан байх ёстой. Тэгээд яагаад асуудал үүсээд байдаг юм. Энэ шийдвэрүүдийн. Шийдвэрүүд юу байх вэ дээ. Төлөвлөгөөнүүдийн хэрэгжилт, юмнуудын хангалт юмнууд ер нь ямар байгаад байгаа юм гээд асуудлууд гарч ирэх юм байна л гэж би төсөөлж харж байна л даа. Ерөнхий мэдээлэл дотроос харахаар зэрэг.

Тийм учраас энэ ерөнхий хяналтын сонсгол зохион байгуулах, нэршил, сэдвээ их зөв олж гэмээн юмнуудаа их зөв харах ийм бололцоо боломж нь бүрдэх ёстой юм шүү. Энэ талаас нь хийе. Тэгээд ямар дүгнэлт юмнууд ерөнхий хяналтын сонсголоос гарч ирдэг юм. Тэрийг нь бид анзаарах ёстой юм болов уу гэсэн нэг ийм бодол байна.

Ер нь бид хэд жоохон энэ уул уурхайн үйлдвэрлэл дээр давамгайлсан эдийн засагтай. Ер нь үүнийгээ амь амьжиргаа гэж бараг хараад явсан. Үүндээ дулдуйдаж асуудлуудыг шийдэх гэж оролдоод байдаг болсон нэг ийм л юм болоод байгаа юм. Энэ нь эргээд үндсэндээ энэ улс үндэстний чинь өөрийнх нь соёл, амьдралын хэв маяг, уламжлалт аж ахуй, өнөө яриад байгаа аялал жуулчлал энэ тэр гээд олон юмтай чинь сөрөг нөлөө үзүүлээд байгаа.

Тийм учраас дан ганц зоосны нүхээр юмыг харахын зэрэгцээ бас иргэдээ нэг эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөл боломжийг нь бодох, ирээдүйдээ бас нэг тийм өв гэдэг юм уу, эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөл боломжийг нь хангасан нутаг орныг нь үлдээх юмнуудыг бодох ёстой юм.

Тийм учраас ер нь яг нарийндаа энэ геологи судалгааны ажил... /минут дуусав/

Р.Сэддорж: Сэдвийг 27 гишүүний ирүүлсэн энэ бичиг дээр л тогтсон юм байна. Байнгын хорооноос тогтоогоогүй юм байна.

Ингээд М.Бадамсүрэн гишүүн.

М.Бадамсүрэн: Миний хувьд өмнө нь энэ газрын ховор элемент, газрын тос, уран зэрэг стратегийн ач холбогдолтой ашигт малтмалыг олгохдоо Засгийн газар зөвхөн шийдвэр гаргах. Өөрөөр хэлбэл Ашигт малтмал, газрын тосны газрын кадастрын хэлтэс олгодог биш. Бүр шаардлагатай Улсын Их Хуралд үүнийг танилцуулж байх.

Өөрөөр хэлбэл хайгуул, ашиглалтын зөвшөөрөл олгохоосоо өмнө энэ процессыг явуулах ёстой гэдгээр зарчмын зөрүүтэй саналыг гаргаж байсан. Харамсалтай нь тэр үед Байнгын хороо Улсын Их Хурал энэ дээр нэлээд гишүүд их олон юм ярьсан. Энэ бараг болохгүй ээ, бүтэхгүй ээ гээд.

Одоо тэр чинь эргээд энэ дээр ирж байгаа юм. Зүй нь өнөөдөр нэгэнт зөвшөөрөл өгснийхөө араас үүнийг сонсгол хийх биш, олгох уу, олгохгүй юу гэдэг дээрээ сонсгол хийх ёстой.

Тэгэхээр бүх юм чинь уруу байна. Өмнө нь зарим дарга нарын өөрийнхөө туйлын зөв гэж бодож байсан юмнууд чинь буруу байна гэдэг нь цаг хугацааны туршид нотлогдож байгаа юм. Үүнийг би хариуцлагатайгаар хэлье гэж бодож байна. Нэг.

Хоёрдугаарт нь, ард иргэд яагаад уур уурхайг эсэргүүцээд байгаа юм бэ гэж. Яагаад гэвэл орон нутгийн ард иргэдэд өгөөж очихгүй байна. Би Өмнөговьд очоод бодсон. Хатуу ширүүн уур амьсгалтай тэр нөхцөлд усгүй, хуурай говь цөлд хэдэн тэмээчид өвөг дээдсээрээ нутаглаж, нүүдэллэн амьдарч, тэр нутгийн баялгийг бидэнд үлдээсэн.

Тэгээд харамсалтай нь энэ орон нутагт очих өгөөж ерөөсөө маш бага. Бүгдийг нь төв Засгийн газар татан төвлөрүүлдэг. Тэгээд үүнийг өөрчлөхийн төлөө, орон нутагт өгөөжийг нь хүртээхийн төлөө их олон ярьсан даа. Жилийн туршид ярилаа. Аймгийн Засаг дарга байхдаа ч ярилаа. Одоо ингээд үнэнд гүйцэгдэж байгаа юм.

Багануур, Эрдэнэт, Бор-Өндөрт яагаад хүмүүс шүүмжилдэггүй вэ гэхээр нэгдүгээрт төмөр замаа эхэлж тавиад, тээвэрлэлтийн асуудлаа шийдээд.

Хоёрдугаарт нь, тэнд хотхон, хороолол бариад уурхайчин залуу гэрээсээ ажилдаа явдаг. Гэр бүл нь ажлын байртай, хүүхдүүд нь гэрээсээ сургуульдаа явдаг. Адилхан хөгжиж байгаа. Өгөөж нь тэндээ тэр нутгийн ард иргэддээ очиж байгаа.

Тийм учраас эсэргүүцэхгүй байгаа. Өнөөдөр тэгвэл энэ газрын тос, Оюу Толгой, Тавантолгой цэцэрлэг, сургууль байхгүй тэнд. Гэр бүл нь ажлын байр байхгүй. Хэдэн сэндвичин барилга, хэдэн төмөр контейнер барилгад амьдруулж байгаа. Тэгээд энэ одоо зөв бодлого юм уу? Үүнийг хэзээ засах вэ?

Тэгээд өнгөрсөн борооны хойноос цув нөмөрнө гэдэг шиг нэгэнт олгогдсон лицензийнхээ араас энэ ярьж байгаа. Энэ урвуу, болохгүй байгаа гэдгийн нэг том нотолгоо болж байгаа юм. Тэгээд үүнийгээ засаач ээ гэдгийг нэг жилийн хугацаанд энэ чуулганы танхимд хэлсэн дээ.

Яагаад гэвэл газрын тосны сөрөг нөлөө, уул уурхайн сөрөг нөлөөллийг өөрийн биеэр амссан хүнийхээ хувьд энэ зүйлийг илэрхийлдэг байсан.

Тэгэхээр энэ дээр бүх л уул уурхайн сөрөг нөлөөлөлд өртөөд байгаа юмыг бүгдийг нь сонсох хэрэгтэй. Ганцхан энэ биш.

Р.Сэддорж: О.Батнайрамдал гишүүн.

О.Батнайрамдал: Халзан бүргэдийн ордын асуудлын талаар ерөнхий хяналтын сонсгол хийхийг дэмжиж байна.

Ховд аймагт сүүлийн хоёр, гурван жил нэлээн том асуудлууд болсон.

Тэгэхээр тэнд яг үнэнийг хэлэхэд үнэн шүү. Ард түмэн тэнд популизм хийгээд л давшаад байгаа биш. Тэнд ерөөсөө маш том мэдээллийн тэнцвэргүй байдал байна.

Ер нь Улсын Их Хурлын хянан шалгалтын тухай хуулиар бид хянан шалгах түр хороо байгуулах, ерөнхий сонсгол хийх боломжтой болсон юм. Яг л нэг иймэрхүү асуудлууд дээр хамгийн гол нь ард түмэнд мэдэх эрхээр л бид хангах ёстой юм.

Олон оролцогч талууд байна. Газрын овор элемент дэлхийд ирээдүйтэй гэдгийг хүмүүс ойлгож байгаа. Гэхдээ газрын оврыг бид өмнө нь ухаад, эсвэл олборлоод, эсвэл боловсруулсан туршлага байхгүй учраас газрын ховрыг ойлгохгүй байгаа юм.

Тэгэхээр энэ яг хүн, амьтан, байгальд яг ямар нөлөөтэй юм, эсвэл тэр хайгуул хийхэд үнэхээр тийм асуудалтай юм уу, цаашаа олборлолт явахад үнэхээр асуудалтай юм уу. Үүнийг бүгдээрээ мэдмээр байгаа юм. Яг өнөөдөр бид нар энэ дундаа ярилцсан ч гэсэн нэгдсэн ойлголтод хүрэхгүй шүү.

Тэгэхээр ерөнхий сонсгол хийж бүх оролцогч талуудыг авчраад нэгдсэн ойлголтод л бид хүрэх ёстой. Ерөнхий сонсголын гол утга учир ерөөсөө энэ.

Тэндээс тийм том шийдвэр гарахгүй. Түүнээс юу гарах вэ гэхээр оролцогч бүх талуудыг авчраад ний нуугүй ярилцаад нэгдсэн ойлголтод хүрэх ийм л зүйлийг бид нар хийх ёстой.

Тэгэхээр үүнийг оролцогч бүх талууд хүсэж байгаа байх гэж бодож байгаа. Ховдын ард түмэн хүсэж байгаа. Тэр олборлолт хийж байгаа компани өөрөө саналаа дэвшүүлсэн байна. Нэгдсэн ойлголтод хүрэхгүйгээр бид цаашаагаа энэ асуудлаа шийдэж чадахгүй бол ингээд л олон тал болоод л талцаад л яваад байна гэсэн үг юм.

Тийм учраас Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль ч. Энэ чинь өөрөө Улсын Их Хурлын бас маш том эрх шүү дээ. Ерөнхий сонсгол хийх, түр хороо байгуулах.

Тэгэхээр Оюу Толгойн асуудал дээр ч гэсэн сая Улсын Их Хурал хяналт шалгалтын түр хороо байгуулах Улсын Их Хурлын тогтоолоо баталсан. Үүний бас нэг гол агуулга ерөөсөө л мэдээллээр ард түмнийг тэнцвэртэйгээр хангах үндсэн зарчим л оршиж байгаа юм.

Тийм учраас энэ ерөнхий сонсголыг бид хийх ёстой. Хийж байж бид нэгдсэн ойлголтдоо бүгдээрээ хүрэх ёстой. Зөвхөн нутгийн ард түмэн гэлтгүй Монгол Улс даяараа бид энэ газрын ховор элементийг цаашаа явуулахад ямар асуудалтай байдаг юм бүгдээрээ л ойлгож авах хэрэгтэй. Бүх түвшиндээ ойлгож авах хэрэгтэй шүү.

Тийм учраас энэ ерөнхий сонсгол хийхийг дэмжиж байна. Цаг хугацааны хувьд бас олон нийтийн анхаарал төвлөрсөн тэр цаг хугацаанд байгаасай гэж хүсэж байна.

Тэгэхгүй бол малчид, эсвэл яг сонсох ёстой хүмүүс... /минут дуусав/

Р.Сэддорж: С.Замира гишүүн.

С.Замира: Та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе.

Р.Сэддорж: Б.Бат-Эрдэнэ гишүүнийг нэмээрэй. Уучлаарай. С.Замира гишүүн.

С.Замира: Ерөнхийдөө ард түмний ойлголт сайн өгч чадаагүйгээс болоод л ийм асуудал хаа сайгүй өсөөд байна л даа.

Нэгэнт манай улс эдийн засгаа дэмжье, ялангуяа ашигт малтмалын энэ компаниудыг дэмжин ажиллая гэх юм бол аль болох хурдан хугацаанд асуудлаа шийдвэрлэх ёстой.

Нэгэнт Их Хурал оролцоод байгаа юм чинь энэ ерөнхий хяналтын сонсголоо ойрын хугацаанд хийх нь зүйтэй. Хугацаа алдахгүйгээр хийх ёстой.

Тэгээд асуудал үүсээд байгаа гол шалтгаан нь Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйл нь биелэлээ олохгүй байгаатай холбоотой юм болов уу гээд бодож байна.

Тэр орон нутагт ямар өгөөжтэй, ард түмэнд ямар наалдацтай, орон нутгийг хөгжүүлэх талаар тэр тухайн компани ямар төлөвлөгөөтэй байна. Тэгээд орон нутгийн засаг төр ард түмэнтэй хийсэн, сумын засаг засаг захиргаатай хийсэн гэрээ хэлцээр нь байна уу гэдгийг эхний ээлжид тэр компаниас нь лавлах нь зүйтэй болов уу гээд би бодож байна.

Тэгээд ерөнхий сонсгол гэдэг юуг одоо яг өнөөдрийн энэ юугаар даргыг нь сонгоод тэгээд цаашаа явах нь зүйтэй.

Тэгэхдээ сая нэг гишүүн нь ярьж байна шүү дээ. Заавал нэг хугацаа алдахгүйгээр 9 сар намар гэхгүйгээр ашигт малтмалын эд үе нь болсон зуны улиралд тэрийг алдахгүйгээр аль болох хурдлах нь зүйтэй болов уу гэж бодож байна. Ерөнхийдөө дэмжиж байна.

Р.Сэддорж: Ажлын одоо өнөөдөр зарлалаа гэхэд 14 хоног олон нийтээс санал авах тийм хугацааг нь тавьж өгөх ёстой. Хуулиараа.

Ингээд явахаар бол нэлээн хугацаа авч байгаа юм байна. С.Замира гишүүн.

Б.Уянга гишүүн.

Б.Уянга: Эрхэм гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Халзан бүргэдэйн газрын ховор элементийн төсөл ер нь олон нийтэд ийм их өвөрмөц өөрөөр ойлгогдоод байгаа нь миний бодлоор сошиал дээр хэтэрхий өөр мэдээллийг хэт ихээр хүргэдэг нь. Түрүүн бас хэлээд байсан. Уул уурхайтай холбоотой буруу мэдээллийг түгээхийг л популизм гэж хэлэх бол яг тэр нь яваад байгаа гэж харагдаж байгаа.

Тэгээд энэ ерөнхий хяналтын сонсголын санал дээр гарын үсэг зурсан юм. Тэгээд яагаад зурсан бэ гэхээр ядаж Халзан бүргэдэйн төсөл хэрвээ цаашаа явах юм бол уран олборлогдохгүй гэдгийг л хэлээд өгвөл уг нь зүгээр. Тэгж л бодож зурсан юм.

Тэгэхдээ түрүүн Б.Бат-Эрдэнэ гишүүний хэлсэн дээр бас нэлээн юм бодож суулаа л даа.

Ер нь холбогдолтой бүх мэдээллийг нь хүргэх тэр субъект нь Улсын Их Хурал мөн үү, биш үү. Байгаль орчны яам нь, тэгээд Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам нь, тэгээд Цөмийн энергийн алба байгаа шүү дээ. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны доор байгаа.

Тэгээд ер нь энэ газрын ховор элемент яагаад урантай холбож ойлгогдоод байдаг юм гэхээр Цөмийн энергийн тухай хуулийн “цөмийн бодис” гэдэг тодорхойлолтод газрын овор элемент гэсэн гурван үг байгаатай л холбоотой байгаа юм.

Тэгээд угаасаа энэ төсөл хэрэгжээд явахад бас л Цөмийн энергийн тухай хуулиараа төрийн эзэмшил ороод явдаг асуудал байдаг.

Тэгэхээр Улсын Их Хурал дээр ингээд л аль нэг аймагт хэрэгжих гэж байгаа төсөл болгон ингэж орж ирээд л, гишүүд нэг их завтай юм шиг бүх төслийнх нь мэдээллийг нь сонсоод л суух нь бас зарчмын хувьд зөв юм болов уу, үгүй юм болов уу.

Сонсголын яг энэ механизмыг нь Ховд аймагт зохион байгуулбал яадаг юм. Иргэдийн хурлынх нь гишүүд нь бүгдээрээ байгаад. Тэгээд тэнд олборлох эсэхийг нь Ховд аймгийнхан шийдэх байхгүй юу.

Тэгээд 09 сарын 15-нд ч юм уу, 10-нд ч юм уу Их Хурал дээр тэр сонсгол нь Ховд аймагтаа юу болов гэдгийг нь оруулж ирж танилцуулбал өнөөдөр Улсын Их Хурал яг зөв ажиллах юм шиг санагдаад байх юм.

Тэгээд агаарын бохирдолтой холбоотой ерөнхий сонсгол сая болсон шүү дээ. Сая бид шинээр гишүүд сонгогдоод болсон. Сонсгол бол иргэдэд мэдээлэл өгөх л үйл ажиллагаа байгаа байхгүй юу. Дараа нь тэгээд яах юм гэдэг хариулт байдаг.

Тэгэхээр Улсын Их Хурал дээр бид энэ сонсголыг хийлээ гэж бодоход дараагийн авах арга хэмжээний төсөл ч гэсэн гарч ирэхгүй юм билээ шүү дээ.

Тэгэхээр оруулж ирж байгаа нөхөд байвал Ховд аймагтаа үүнийг зохион байгуулах ёстой биш үү. Дараа нь Улсын Их Хурлын гишүүдэд танилцуулах ёстой биш үү. Яг тэндээс, тойргоос гарсан гишүүд тэр танилцуулах үед нь явж очно л биз. Ийм нэг зарчмын саналтай байх юм. Тэгээд өнөөдөр орж ирнэ гэж мэдсэнгүй. Тэгээд шууд л ороод ирсэн байгаа шүү. Холбогдолтой мэдээлэл байвал бас хариулахад бэлэн байна.

Р.Сэддорж: Энхбатын Болормаа гишүүн үг хэлье.

Э.Болормаа: Өнөөдөр Монгол Улсын Их Хурлын дарга Дашзэвгийн Амарбаясгалан даргын санаачилснаар “Халзан бүргэдэйн” орд газрын

ашиглалтын асуудлаар ерөнхий хяналтын сонсгол явуулах гэж байгааг дэмжиж байгаа.

Миний хувьд дэмжиж гарын үсэг зурсан. Яг газар дээр нь бас Улсын Их Хурлынхаа даргатай хамт тойрогт ажиллаж байх явцад иргэддээ үүнийг хэлэлцээд саналыг нь сонссон байгаа.

Тэгээд би зүгээр тэндээс Байнгын хорооны тогтоолд хэдэн зүйлсийг бас нэмж хэлье гэж бодож байгаа юм.

Яг газар дээр иргэд хэдэн зүйл хэлсэн юм. Энэ хяналтын сонсголд мэдээлэл дунд энэ лицензийг яаж авсан. Анх энэ лиценз олголтоос авхуулаад энэ асуудлыг хэлэлцмээр байна гэж байгаа юм. Яагаад гэвэл өнөөдөр Монгол Улсын түвшинд хайгуулын лиценз олгогдсоны дараа, хайгуулын үйл ажиллагааны явсны дараа ашиглалтын буюу “А” лиценз олгогддог байтал энэ аж ахуйн нэгж давхар “Х”, “А” лиценз аль алинтай юм гэдэг зүйлийг хэлсэн.

Тэгэхээр үүнийг сонсголын явцад онцгойлон анхаарах ёстой. Мөн иргэд хэлж байгаа зүйл бол зөвхөн байгаль орчинд үзүүлэх нөлөөллөөс гадна, одоо сая О.Батнайрамдал гишүүн хэллээ. Хүн ам, эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг онцгойлон мэдээлэлжүүлэх энэ асуудлыг хэлсэн байгаа.

Гуравт нь, зарим иргэд. Бүгд бас биш. Бид тов тогтоох асуудал ярьж байгаа учир. Бүгд биш. Зарим иргэд юу гэсэн бэ гэхээр хадлан тарианы цагийн дараа байвал бас зүйтэй шүү гэдэг асуудлыг хэлсэн.

Тэгэхээр үүнийг сонсгол дээрээ товоо тогтоохдоо анхаараарай гэж хэлье.

Тэгээд сая нэг гишүүн бас энэ даргалагчийн хувьд Б.Баярбаатар Байнгын хорооны даргын нэрийг дэвшүүлж байгаа миний хувьд дэмжиж байна гэдгийг хэлье.

Эцэст нь энэ зөвхөн Ховд аймгийн асуудал биш юм гэдгийг бас онцгойлон хэлмээр байгаа юм. Монгол Улсад газрын ховор элементийг олборлож үзээгүй. Монгол Улсын хэмжээнд анхны урдаа барих ч юм уу, илүү урд яваа төслийн нэг бол энэ Ховд аймагт байрлах Халзан бүргэдэйн ордын төсөл байгаа.

Гэхдээ энэ зөвхөн Ховдын асуудал биш. Энэ бүс нутгийн асуудал, энэ Монгол Улсын асуудал. Цаашдаа газрын ховор элемент дээр бид ямар байр суурьтай байх, ямар бодлого тодорхойлох ёстой вэ гэдэг ийм асуудал явж байгаа.

Хэрвээ бид аймаг аймагт нь хаяад явах юм бол бид яах юм. Оюу Толгойг Өмнөговийн тэндээ нэг сонсгол хийчих ээ. Дараа нь их хурал сонсьё гэх юм уу. Үгүй шүү дээ. Энэ бол стратегийн хэмжээний яригдах ёстой асуудал.

Сая М.Бадамсүрэн гишүүн ч гэсэн хэллээ. Ураны асуудал, газрын тосны асуудал, газрын ховрын асуудал. Энэ стратегийн асуудал. Үүнийг бид Улсын Их Хурлаар хэлэлцдэг байх ёстой. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хэмжээнд ярьдаг байх ёстой гэдэг энэ асуудлыг бид Улсын Их Хурал дээр ерөнхий хяналтын сонсгол зохион байгуулж байж нээлттэй хэлэлцэх нь зүйтэй гэж бодож байна. Үүнийг бүгд баруун бүс нутгийн ард иргэд хүсэж байгаа. Зөвхөн Ховд гэж битгий хараасай гэж би бас нийт гишүүддээ уриалмаар байна. Зөвхөн энэ тойргийн асуудал биш шүү гэдэг бас дахин хэлье.

Р.Сэддорж: Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн.

Б.Бат-Эрдэнэ: Нээлттэй, ил тод мэдээлэлтэй холбоотой асуудал яригдаж байгаа.

Өнөөдөр энэ Байнгын хороон дээр ч гэсэн нээлттэй, ил тод мэдээллийн асуудлыг хөндмөөр байгаа.

Байнгын хорооны хуралдаан хуралдах гэж байхад мэдээллийг зөвхөн тогтоол л орж ирж байна шүү дээ. Аж ахуйн нэгж нь ямар хүсэлт өгсөн юм, иргэдээс ямар хүсэлт ирсэн юм. Энэ нь бид нарт танилцуулагдахгүй юм уу?

Байнгын хорооны баахан референтүүд гээд нөхдүүд байгаад байдаг. Энэ мэдээллийг өгөөгүйгээс болоод Улсын Их Хурлын гишүүд хүртэл мэдээллийн төөрөгдөлд орж байна шүү дээ. Урдаас тэгээд нэг л их хууль сануулсан хүмүүс л байх юм. Бид гэсэн хууль сануулж болно шүү дээ. Тэгвэл.

Тэгээд яагаад энэ Улсын Их Хурлын гишүүдэд мэдээллээ Та нар бүрэн өгөхгүй байгаа юм.

Яг үнэндээ байна шүү дээ. Тийм ээ. Та нар бодлого гаргаж байгаа төрийн захиргааны төв байгууллагын чадамжийг үүгээрээ сулруулж байгаа шүү. Би үүнийг бүр хатуу хэлье.

Өнөөдөр ингээд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны эрхлэх асуудалд бид ингээд оролцож эхэллээ. Энэ бол оролцож байгаа хэлбэр.

Эрдэс баялгийн яамны асуудалд бид оролцож эхэллээ. Би эсэргүүцээд байгаа юм биш. Ерөнхий хяналтын сонсголыг дэмжиж байна. Иргэд төрөөсөө мэдээлэл авдаг байх ёстой. Аливаа хязгаарлалтгүйгээр бүх мэдээллийг бүр Ховдод нь очоод сонсгох хэрэгтэй. Тэгвэл. Тэр саналтай би санал нэг байна. Ховдод нь аваачиж байгаад энэ ерөнхий хяналтын сонсголыг хэдүүлээ хийе.

Гэхдээ яг өнөөдрийн энэ хэлэлцэж байгаа асуудлын хүрээнд Байгаль орчны яам эрх зүйн чадамжаа алдаж байна шүү. Уул уурхайн яам эрх зүйн чадамжаа алдаж байна шүү.

Цаашдаа алт хөтөлбөртэй холбоотойгоор хэдүүлээ Ноён уулаа бас ерөнхий хяналтын сонсгол хийе. Утаагаа хийе.

Ер нь одоо явж байгаа төслүүдээс бусад бүх төслүүдийг хэдүүлээ ер нь хаашдаа энэ бол уурхайгаа зогсоож байгаа юм бол ерөнхий хяналтын сонсголоо хэдүүлээ хийе.

Байгаль орчны яам ерөнхий үнэлгээ, нарийвчилсан үнэлгээ, менежментийн төлөвлөгөө баталдгаа ч бас больё. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам хуучны нэрээр. Одоо Эрдэс баялгийн яам. Энэ хайгуул, ашиглалтын зөвшөөрөл олгодгоо ч бас больё.

Хэдүүлээ Улсын Их Хурал дээрээ, Байнгын хороон дээр энэ асуудлуудаа дуудаж авчирч байгаад бүх асуудлыг хэдүүлээ шийдье.

Тэгээд эдийн засгаа босгох тухай ч хэдүүлээ яриад, хөндөхөө ер нь больё. Тэр өмсөж зүүдэг юмнуудаа ч больё. Ний нуугүй хэлэхэд. Би аль нэг компани, аль нэг ордыг өмөөрөөд байгаа юм биш. Зарчим чинь энэ дээр яваад байна. Зарчмаа барихгүй юм уу. Үүнийг л хэлж байгаа юм.

Р.Батболд: Нээлттэй байдал. Жоохон мэдээллийн дутуу байдлаас болоод ийм асуудал үүсчихлээ гэж р хараад байна.

Тэгэхээр одоо гишүүд энэ тогтоолын төсөл. Ер нь яах вэ энэ компаниасаа юм уу, иргэдээсээ хүсэлт нь ирээд тэгээд Их Хурлын дарга Д.Амарбаясгалангаас дэд дарга руу хүсэлтээ яваад дөнгөж сая энэ тараасан. Тэр хүсэлт нь бол алга байна шүү дээ. Зөвхөн Д.Амарбаясгалан даргын өгсөн, Х.Булгантуяа дарга руу сонсгол хийж өгөөч ээ гэсэн хүсэлт нь Байнгын хороодод ирсэн учраас энэ нь л байж байгаа юм байна. Түүнээс тэр цаад талын компанийн хүсэлт нь байхгүй юм байна. Энд.

Тийм. Ерөнхий сонсгол бол яах вэ Байнгын хороодын эрхлэх хүрээний асуудал учраас Байнгын хорооны гишүүд байх ёстой. Тэд нар шийдвэр гаргах ёстой юм байна.

Тэгэхээр Төрийн ордондоо хийх юм уу, Ховддоо хийх юм уу гэдгээ Байнгын хороон дээрээ шийдэж байгаад хаана хийхээ шийдэж болох байх. Тийм ээ.

Тэгэхээр одоо бол зүгээр сонсгол даргалагчаа эхлээд сонгох ажил л болох гээд байх шиг байна. Энд 2 нэр дэвшигч гарчихлаа. Тийм. Гишүүдээ дуудаж байгаад сонсгол даргалагчаа эхлээд сонгочихмоор байна.

Ер нь бүр дэлгэрүүлэе л гээд байгаа шүү дээ. Өшөө нийгмийн асуудал, дээрээс нь эдийн засгийн асуудлууд. Яах вэ, сонсгол дээр тэртээ тэргүй гишүүдийн асуулт дотор эд нар гарч ирэх болов уу гэж бодоод байна шүү дээ. Эдийн засгийн асуудал нь ч хөндөгдөх байх, нийгмийн асуудал нь ч хөндөгдөөд явах байх л гэж бодоод байна.

Тийм. Энэ чинь нөгөө олон нийтийн нээлттэй хэлэлцүүлэг бол орон нутагт нь хийчхэж болох юм байна л даа. Уг нь. Тэгээд энэ чинь Ерөнхий хяналтын сонсгол болохоор Байнгын хорооны хүрээнд. Тийм. Тэрийг бэлтгэл хангах хүрээнд хийж болно шүү.

Гарсан саналаар нь тэгвэл энэ нэг гээд нөгөө ерөнхий хяналтын сонсголыг Халзан бүргэдэйн орд газрын ашиглалтын асуудлаарх. Тийм. Ашиглалт сэдвээр болгоод явах уу? Тэгээд явуулчих уу? Тийм. Ерөнхийлөх гээд байна. Тэгэх үү? Нэгдүгээрх дээр байгааг. Тэгвэл нэгдүгээрхийг заслаа шүү.

Ерөнхий хяналтын сонсголыг Халзан бүргэдэйн орд газрын ашиглалтын асуудлаар. Ашиглалт сэдвээр. Тийм. Орд газрын ашиглалт сэдвээр.

Үгүй ээ, яах вэ, энэ хүсэлт нь өөрөө тийм болохоор хүсэлтийнх нь дагуу болгоё гээд байна л даа. Энэ хүрээндээ гээд. Үүнийхээ хүсэлт дээр зөвхөн ашиглалт гээд л тавьсан юм байна л даа. Ашиглалтын асуудлаар гээд.

Одоо эхний мөр байна шүү дээ. Ерөнхий хяналтын сонсголыг “Халзан бүргэдэйн” орд газрын ашиглалт сэдвээр гээд л шууд доошоо. Болж байна уу?

Яая, зүгээр сэдвээр нь явчихвал яасан юм бэ? Эсвэл зүгээр бүр орд газрын сэдвээр гээд тавьчихъя л даа. Тэгвэл ашиглалт гэж яах гээд байгаа юм. Аан. Тэгье. Тэгвэл яах юм? Ашиглалт сэдвээрээ. Тийм. Хүсэлтээр нь явлаа. Үүнийг ингээд тохирлоо. Санал хураая.

Одоо сонсгол даргалагчийнхаа саналыг хураая. Хоёр санал байгаа. Нэг нь Б.Баярбаатар, нөгөөх нь С.Цэнгүүн гишүүн. Тийм.

Эхнийх нь дэмжигдвэл дараагийнх нь хураахгүй шүү дээ. Тийм.

Б.Бейсен: Санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтад бэлтгээрэй. Хуруугаа уншуулаарай.

Ерөнхий хяналтын сонсголыг даргалагчаар Б.Баярбаатарыг сонгоё гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

60.6 хувиар Б.Баярбаатар гишүүн дэмжигдлээ. Хяналтын сонсгол даргалагчаар.

Хугацаан дээр бас тохирох юм. 09 сарын 10 гэдэг. Нөгөө санал асуулга авах, иргэдийн оролцоог хангах зорилгоор доод тал нь 14 хоногоос дээш хугацаа, сар хүртэл байх ёстой. Тэр доод талын хугацааг зарласнаас хойш 30 хоног байхгүй юу.

Тэгэхээр чинь наашилбал хуулиараа болохгүй юм байна. 09 сарын 20 гэдгээр санал хураалт явуулъя гэж байна. Бас хадлан тариалан, ургац хураалтын үе гэж байна.

09 сарын 20 гэдгээр санал хураалт явуулъя. Санал хураалтад бэлдээрэй. 09 сарын 23-нд гээд хяналтыг нь сонсгол хийхээр. Санал хураалтад бэлдээрэй. Бэлэн байгаарай. Санал хураалтад.

Ерөнхий хяналтын сонсголын хугацааг 09 сарын 23 гэдгээр санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

63.6 хувиар дэмжигдлээ.

Ерөнхий хяналтын, сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай Байнгын хорооны хамтарсан тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Тогтоолын төсөл 63.6 хувиар батлагдлаа.

Өнөөдрийн хэлэлцэх асуудал дууссан тул гишүүдэд баярлалаа.

Хамтарсан хуралдаан 1 цаг 16 минут үргэлжилж, 11 цаг 49 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД